



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар

A/45

Онги

┌ Мал аж ахуйн салбар болон төв, ┐  
суурин газрын 2023-2024 оны өвөлжилт,  
хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/337 дугаар захирамж, Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/459 тоот албан захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал аж ахуй болон төв суурингийн 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах, ажлын явцад хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 10 дугаар сарын 20-ны дотор хангаж, тайлан мэдээг Хүнс, хөдөө аж ахуйн газарт, төв суурийн газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 09 дүгээр сарын 30-ны дотор хангаж, тайлан мэдээг болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст явуулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА

Сумын Засаг даргын орлогчийн ажлын албаны 09  
сарын 06-ны өдрийн 47 дугаар  
захирамжийн хавсралт

Мал аж ахуйн салбар болон төв суурийнгийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

Онги багийн Засаг дарга

Мааньт багийн Засаг дарга

Найз багийн Засаг дарга

Төгрөг багийн Засаг дарга

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч

Цагдаагийн хэсгийн мөрдөгч

Засаг даргын тамгын газрын дарга

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Эрүүл мэндийн төвийн дарга

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

Соёлын төвийн дарга

Шатахуун түгээх станцын дарга нар

Сумын цаг уур, орчны шинжилгээний өртөөний дарга

Эрчим хүчний байцаагч

Ган-Илч ХХК

Мэдээлэл холбооны газрын Сайхан-Овоо суман дахь

салбарын эрхлэгч